

9

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨСӨЛТ АЖИЛ ЭРХЛЭЛТЭД НӨЛӨӨЛӨХ НЬ/

Б.Лхагвасүрэн.

20-р зууны эхээр манай улсад хэд хэдэн алтны уурхайнууд ажиллаж байсан ба 1940 оноос эхлэн уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, хайгууллын судалгаа идэвхтэй хийгдэж эхэлсний үр дүнд Монгол Улсад өнөөгийн байдлаар 80 гаруй төрлийн ашигт малтмалын 6000 орчим орд илэрц тогтоодсон байна.

Сүүлийн 18 жилд тус салбарт дотоодын хувийн хэвшлийнхэн, АНУ, Канад, Австрали, Хятад, Япон, Солонгос зэрэг олон улсын хувийн компаниудын хөрөнгө оруулалт хийгдэж, өнөөгийн байдлаар Монголд “зэс, молибдены баяжмалын Эрдэнэт үйлдвэр (Монгол – ОХУ хамтарсан үйлдвэр) 1 аж ахуйн нэгж катодын зэс, 127 аж ахуйн нэгж алт, 44 аж ахуйн нэгж жонш, 28 аж ахуйн нэгж нүүрс, 2 аж ахуйн нэгж газрын тос тус тус олборлож байна”²⁵.

2004 онд хийгдсэн Дэлхийн Банкны судалгааны дүнгээс харахад 40 сая гектар буюу Монгол Улсын нийт нутгийн 26% орчим хувийг эзэлсэн газар нутагт хайгуулын ажлыг хийх 2595 лицензи, зөвшөөрлийг олгосон байна²⁶.

2008 онд Монгол орны хэмжээнд хувийн хөрөнгөөр 27,4 сая га талбай бүхий 2269 орчим тусгай зөвшөөрлийн талбайд геологи хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн байна./2009 оны 04 сарын 16 ны байдлаар/

²⁵ АМХЭГ-ийн мэдээлэл, 2006

²⁶ Дэлхийн банк, 2004. Монгол улсын уул уурхайн салбарын судалгаа

2008 онд нийт 173,4 тэр бум төгрөгийн геологи хайгуулын ажлыг хийсэн байна.

Манай алт олборлогч үйлдвэрүүд 15184 кг (ҮСГ-ын эх сурвалжаар) алт олборлосон нь 2007 онд дэлхийн хэмжээнд үйлдвэрлэсэн 2340 тонн алтны 0.6% болж байна.

Эрдэнэт УБҮ 2008 онд 1783 тонн молибдени үйлдвэрлэсэн нь дэлхийн хэмжээнд 212 мянган тонн молибдени үйлдвэрлэсний 1.1%-ийг эзэлж молибдений үйлдвэрлэлтээрээ 10 дугаарт орж байна.

Монгол улсын уул уурхайн салбар 2007 онд зэсийн баяжмал, молибдений баяжмал, жоншны баяжмал, бүхэллэг жонш, алт, нүүрс, катодын зэс, гянт болдын баяжмал, төмрийн хүдэр, давс, барилгын материалын түүхий эд үйлдвэрлэсэн бөгөөд бүтээгдэхүүний өсөлтийг сүүлийн жилүүдтэй харьцуулах зорилгоор 1997-2008 оны уул уурхайн бүтээгдэхүүн гаргалтын хэмжээг хүснэгтээр үзүүллээ.


Хүснэгт 1. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүн гаргалт
/2009.01.01-ний байдлаар/

	Бүтээгдэхүүн	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008
1	Бүхэллэг жонш,мян.тн	44,3	45,9	53,7	87,4	71,8	9,0	80,5	206,7	233,4	239,4	245,0	219,1
2	Элотацын баяжмал,мян.тн.	130,1	122,5	100,0	11,4	127,3	16,1	116,2	102,7	93,7	108,3	109,9	115,7
3	Баяжмал дахь зэс,мян.тн	124,4	125,4	126,7	125,2	133,5	1,7	30,27	130,0	126,3	129,7	130,2	126,8
4	Баяжмал дахь молибдени,тн	2202	1993	1953	1336	1423	590	1793	1141	1153	103,9	978,3	783,6
5	Цагаан тугалганы баяжмал /50%/ , тн	19,6	-	-	-	-	-	-	22,0	47,0	-	27,5	87,5
6	Гянт болдын баяжмал /68%/ ,тн	48,0	63,0	40,0	76,0	93,0	1,0	17,0	77,1	78,2	82,2	244,5	141,9
7	Нүүрс, мян.тн	4922	5057	4964	5185	5141	544	566,1	6665	517,1	074,1	237,6	591,6
8	Алт/х.ц./, кг	8000	10040	10146	11500	2059	383	0837	8500	1900	1267	8087	5184 охир
9	Катодын зэс,тн	2758	2319	535,1	632,1	1476	500	1341	376,1	474,5	518,4	106,5	586,6
10	Төмрийн хүдэр, мян.тн	-	-	-	-	-	-	-	33,5	167,7	180,8	265,1	387,4
11	Цайрын баяжмал, мян.тн /чийгтэй/	-	-	-	-	-	-	-	-	22,8	109,9	154,7	143,6
12	Цувимал зэс,тн	-	-	-	-	-	-	-	-	195,5	221,2	-	-
	Молибденийн исэл,тн	-	-	-	-	-	-	-	-	-	157,8	2664,0	2112,2

2008 онд уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ /мөнгөн дүнгээр/ өнгөрсөн онтой харьцуулахад 6.2%-иар, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувийн жин 3.4 пунктээр буурчээ.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2007 онд нийт экспортын бүтээгдэхүүний 78.4%-ийг эзлэж байсан бол 2008 онд 80.7%-ийг эзэлж 2.3 пунктээр нэмэгджээ.

Зураг 1. ДНБ болон уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ, сая төгрөг



Судалгаанаас үзэхэд²⁷, сүүлийн жилүүдийн Монгол Улсын эдийн засгийн өсөлт, экспортын өсөлтийн томоохон хувь нь уул уурхайн салбарын өсөлтөөр хангагдаж ирсэн байна.

Уул уурхайн салбарын энэхүү үсрэнгүй өсөлт нь макро эдийн засгийн гол үзүүлэлт болох ажил эрхлэлтэд хэрхэн нөлөөлж болох талаар авч үзье.

Одоогоор манай улсын нийт хүн амын 38.3 хувь нь ажиллагсад байгаа ба 2008 оны байдлаар тооцоолсон ажилгүйдлийн түвшин 3.1 хувьтай байгаа билээ.

1960-1990 онд манай улсын хүн амын дундаж өсөлт 2.7 хувь байсан бол 1995-2001 онд 1.4 хувь, 2002 онд 1.2 хувь болж буурсан байна. Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт харьцангуй нэмэгдэх хандлагатай байгаа нь төр засгийн нийгэм эдийн засгийн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ түүнчлэн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт зэрэгтэй шууд холбоотой.

2004 оны байдлаар Монгол улсад нийт ажиллагдсын тоо 950 мянган хүн байсан, үүнээс уул уурхайн салбарт албан ёсоор 33.5 мянган хүн ажиллаж байсан бөгөөд 1994-2004 оны дүнгээр уул уурхайн салбар дах ажил эрхлэлтийн өсөлт улсын

²⁷ ННФ, МУИС, ЭЗС. Эдийн Засгийн эрх чөлөөний тойм 2006

дундаж өсөлтөөс илүү өндөр байна. Энэ нь тус салбарын өсөлт сүүлийн жилүүдэд эрс эрчимжсэнийг харуулж байгаа юм.

Тухайлбал 1994-2004 онуудад Монголын эдийн засаг дах нийт ажиллагсдын тоо 1994 оны 759 мянгаас 2004 онд 950 мянган хүн буюу 25 орчим хувиар өссөн байхад, уул уурхайн салбар дах ажиллагсдын тоо 14.6 мянгаас 33.5 мянган хүн буюу 2.29 дахин өссөн байна (2005 онд 39.8 мянган хүн). Тус салбарын ажил эрхлэлтийн өсөлт ялангуяа 2001 оноос эрчимжиж 2003 -2005 онд үсрэнгүй өсчээ.

Тус салбарт ажиллаж байгаа нийт ажил эрхлэлт нь зөвхөн Монголын иргэдийн ажил эрхлэлтээр хязгаарлагддаггүй, тус салбарт олон орны гадаадын мэргэжилтэн, ажилчид ажиллаж байгаа юм. Жишээлбэл, уул уурхайн салбарын ажил олгогч компаниудаас хамгийн том нь Монгол-ОХУ-ын Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрт 6240 хүн ажиллаж байгаа бөгөөд 4545 нь үйлдвэрлэлийн ажиллагсад юм. Эдгээрийн дотор 600-аад ажиллагсад нь ОХУ, Казахстан болон бусад ТТУХ-ны улсуудын иргэд ба үлдсэн хэсэг нь монгол ажилчид, инженер техникийн ажилтнууд билээ. 2006 онд Монгол Улсад 72 орны 12.8 мянган гадаадын иргэд ажиллаж амьдарч байсан²⁸ бөгөөд 2005 оноос гадаадын иргэдийн тоо нь 31.4%-иар өссөн. Нийт гадаадын иргэдийн 62.2 хувийг БНХАУ-ын иргэд, 11.7%-ийг ОХУ-ын иргэд, 3.4%-ийг БНСУ-ын иргэд, 2.5%-ийг АНУ-ын иргэд эзэлж байгаа бөгөөд нийт гадаадын иргэдийн 50 орчим хувь нь уул уурхайн салбарт ажилдаг. Тэгэхлээр, нийтдээ тус салбарт Монголын 39 мянган иргэд, гадаадын 6 мянган иргэд ажиллаж байгаа гэсэн үг. 2005 онд Монголд нийтдээ 968 мянган ажиллагсд бүртгэгдсэн байсан бөгөөд уул уурхайн салбарт ажиллаж байгаа 39.8 мянган хүн нь нийт ажиллагсдын дөнгөж 4.1% -ийг л бүрдүүлж байсан юм.

Уул уурхайн салбар нь хөдөлмөрийн хүчин зүйлээс илүү капиталын хүчин зүйлсийн ашиглалт ихтэй тул үйл ажиллагааны урт хугацаанд ажиллагсдын тоо тогтвортой бөгөөд харин ч буурах хандлагатай байгаа юм.

Гэхдээ уул уурхайн салбарын өсөлтөөс хүртэх өгөөж нь уул уурхайн бусад салбарын хувьд маш их гэдгийг нийт ажиллагсадын тооны өсөлтөөс харж болох юм. Макро эдийн засгийн орц гарцын загварыг ашиглан 2040 он хүртэл тооцоолол хийж үзэхэд ажил эрхлэлттэй холбоотой дараах үр дүн гарсныг тайлбарлая.

Үүнд уул уурхайд томоохондоо тооцогдох зөвхөн Таван толгойн орд газрыг ашиглалтад орсноор олборлолтод зарцуулах зардлыг тусган өгч тухайн үйлдвэрт ажиллах ажиллах ажиллагсдыг төслийн хүрээнд тооцоолсон болно.

Таван толгойн орд газрын ажиллагсадын 90 хувь нь монгол ажиллагсад байх ба 2009 онд 358 байснаа 2010 онд 648 болж цаашдаа 2033 оноос эхлэн 804 ажилчинтай байхаар тооцоолсон томоохон үйлдвэрүүдийн нэг юм.

Уул уурхайн бусад салбарт ажиллагсдын тооны өсөлтийг дараах хүчин зүйлсээс хамааруулан тооцоолсон.

- Цалингийн өсөлт
- Хүн амын өсөлт

²⁸ МОНЦАМЭ 16.10.2006 Монгол Улсад хичнээн гадаадын иргэд ажилдаг вэ?

- Уул уурхайн салбарт ажиллагсдын тоо

2006 онд уул уурхайн салбарт 41900 хүн ажиллж байгаа 2009 онд Таван толгойн орд газар олборлолтоо хийж эхэлснээр 2010 онд уул уурхайн салбарт ажиллагсад 46249 болж одоогийнхоос 10 гаруй хувиар нэмэгдэж, уул уурхайн бусад салбарт ажиллагсад олборлолтын хэмжээнээс хамаарахгүйгээр 2010 онд 12450 хүнээр нэмэгдэх тооцоолол гарсан.

Таван толгойн орд газар 2010 онд ашиглалтад орж олборлолт хийж эхэлснээр манай улсын ажил эрхлэлт болоод ажилгүйдлийн түвшин хэрхэн өөрчлөгдөхийг тооцоолж үзсэн болно. ӨӨрөөр хэлбэл энэхүү орд газрын олборлолт нь ажил эрхлэлтэд шууд болон шууд бусаар нөлөө үзүүлж 2038 он гэхэд ажлын байрны хомсдолгүй байх нь харагдаж байна.

Хүн амын өсөлтийг, орд газар ашиглалтад орж манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн болоод ажиллагсадын цалингийн түвшин өсөж нийгмийн халамжид зарцуулах төсөв нэмэгдсэнээр хүн амын өсөлтийн хурд 1.4 хувь байхаар тооцооллыг хийж үзэхэд 2038 онд нийт хүн ам 4048727 болохоор байна.

2002 *iiü äàéäüäàð ìèèð ðçí àü 0-14 ìàñü ðçí àì 32,7 ðóâèéä, 15-64 ìàñü ðçí àì 53,8 ðóâü, 65-ààñ äýýø ðçí àì 3,5 ðóâèéä ýçýýð àíèñü äàéìà. / ÑÑ 2003 ü/*

Тооцооллыг орд газрын жилийн олборлолтын хэмжээг 15 сая тн, 30 сая тн гэсэн 2 хувилбараар хийж ажил эрхлэлттэй холбоотой дараах мэдээллүүдийг харьцуулан харуулав.

Хүснэгт 2. Уул уурхайн салбарт ажиллагсад

Он	Олборлолт 15 сая тн	Олборлолт 30 сая тн
2010	46,249.76	46,249.76
2014	45,998.00	45,998.00
2018	44,185.49	44,185.49
2022	42,441.41	42,441.41
2026	40,771.93	40,771.93
2030	39,165.35	39,165.35
2034	37,622.08	37,622.08
2038	36,139.62	36,139.62

Эх үүсвэр: Судалгааны багийн тооцоолол, 2007

Сүүлий жилүүдэд манай улсын уул уурхайн салбарт ажиллагсадын тооны өсөлт дунджаар 2.5 хувь байгаа ба орд газар ашиглалтад ороод 2010 онд хамгийн ихбуюу 46249 ажиллагсадтай байх ба түүнээс хойш буурч байна. Мөн энэ салбарт ажиллагсадын тоо олборлолтын хэмжээнээс хамаарахгүйгээр тогтмол байх бөгөөд

урт хугацаанд ажиллагсадын тоо буурч байгаа нь тухайн салбар хөдөлмөрөөр илүү капитал тоног төхөөрөмжөөр өргөжилт хийдэг гэдгээр тайлбарлагдана.

Харин уул уурхайн бус салбарт ажиллагсадын тоо буюу ажлын байрны өсөлт нь олборлолтын хэмжээнээс шууд хамаарах бөгөөд 2038 оны байдлаар 15 сая тонн олборлолтын үед 2468791 болж манай улсын ажил эрхлэлт бүрэн хангагдаж, 30 сая

тонн олборлолтын үед 3418209 болсон нь ажлын байрны илүүдэлтэй болж байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Уул уурхайн бус салбарт ажиллагсад

Он	Олборлолт 15 сая тн	Олборлолт 30 сая тн
2010	1,030,823.41	1,029,892.59
2014	1,207,474.18	1,223,485.97
2018	1,393,889.95	1,545,591.93
2022	1,586,120.32	1,894,245.94
2026	1,789,196.28	2,228,662.92
2030	2,007,962.31	2,579,011.72
2034	2,236,365.08	2,963,625.02
2038	2,468,791.51	3,418,209.96

Эх үүсвэр: Судалгааны багийн тооцоолол, 2007

Олон улсын дүн шинжилгээний байгууллагын үзүүлэлтүүд 2007-2038 онд 15 сая тонн олборлолтын үед 222963 ажил байрны өсөлт, 30 сая тонн олборлолтын үед 3418209 ажил байрны өсөлтөөс үзүүлж байна.

Уул уурхайн бус салбарт ажиллагсадын тоо 2007 онд 104808, 2010 онд 122963, 2014 онд 138042, 2018 онд 158612, 2022 онд 1762138, 2038 онд 2468791 болж өсөж байна. /Таблица 4/

Хүснэгт 4. Улсын хэмжээний нэрлэсэн дундаж цалин

Он	15 сая тн	30 сая тн
2010	222963	220917
2014	490248	515893
2018	703558	873039
2022	878579	1146205

2026	1029497	1338079
2030	1164290	1494053
2034	1281066	1630734
2038	1380042	1762138

Эдийн засагт аливаа салбар бусад салбаруудтай хамт үйлдвэрлэлийн шат дамжлагаар хэзээд байнга холбоотой байдаг тул, уул уурхайн салбарын өсөлт бусад салбаруудын өсөлтийг дэмжиж, нийтдээ түүнээс илүү их ажлын байрыг бий болгож байдаг юм. Үүнтэй адил уул уурхайн салбар өөрийн ажиллагаанд бусад салбаруудаас орцыг шаарддаг. Жишээ нь, уул уурхайн салбар тээвэр, худалдаа, үйлчилгээ зэрэг салбаруудтай хамтран ажиллаж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ (энэ нь албан болон албан бус ашигт малтмалын олборлолтын аль алинд нь хамаарна). Иймээс уул уурхайн салбар зайлшгүй бусад салбаруудын үйл ажиллагааг дэмжиж, тэдгээр салбаруудад шинэ ажлын байруудыг бий болгодог. АНУ-ын Вестерн Эдийн Засгийн судалгааны төвийн тооцоог, Австралид уул уурхайн салбарт шинээр үүссэн 1 ажлын байр бусад салбаруудад 2.7 байрыг бий болгож байхад Чили болон Энэтхэгт 3.3 болон 5 ажлын байруудыг бүтээдэг байна. АНУ-ын Невада мужид энэ үзүүлэлт 2-тэй тэнцдэг.²⁹ Филиппин улсад уул уурхайн салбарын нэг ажлын байр бусад салбаруудад 4-10 ажлын байрыг бий болгодог гэж Филиппины сенатын Эдийн Засгийн төлөвлөлтийн газар нь үздэг.³⁰

Уул уурхайн салбар бусад салбаруудын ажил эрхлэлтэд үзүүлж байгаа эерэг нөлөөг тооцох нь бодлого боловсруулалтын хувьд нилээд чухал байдаг бөгөөд энэ хэсэгт бид уул уурхайн салбар Монгол Улсад нийтдээ хичнээн ажлын байрыг шууд бөгөөд бусад салбарын өсөлтийг дэмжих замаар (шууд бусаар) бий болгож байгааг шинжлэх болно³¹. Үүний тулд эдийн засаг дах эрэлтийн бөгөөд нийлүүлэлтийн холбоосын тухай ойлголт, шууд бус үржүүлэгчийн нөлөөг судлах шаардлагатай юм.

Хөгжлийн эдийн засгийн онолд салбар хоорондын холбоосын тухай ойлголт байдаг. Үүнийг анх алдартай эдийн засагч Алберт Хиршман³² болон бусад хөгжлийн эдийн засагчид дэлгэрүүлсэн бөгөөд гол санаа нь эдийн засгийн хөгжилд аливаа салбарын өсөлт, хөгжил зайлшгүй бусад салбартай нягт холбоотой байдагт

²⁹ Facilitating economic cooperation in eastern parts of Inner Mongolia autonomous region, PRC and Mongolia. Minerals market assessment, 2002, Prepared by: Transportation and economic research associates, Inc. (TERA), U.S.A.

³⁰ Extracting Growth from Mining, Senate Economic Planning Office, 2005

³¹ Албан бус ашигт малтмалын олборлолт хэд хэдэн онцлогтой байдаг: харьцангуй бага хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг, хөдөлмөрийн орц ихтэй. Албан бус олборлолтын нийт хэмжээ нь алтыг эс тооцвол Монгол Улсад олборлож байгаа нийт ашигт малтмалын олборлолтын маш бага хувийг эзэлдэг тул энэ бүлгийн судалгаанд лбан есны уул уурхайн салбарын статистикийн тоог ашигласан болно.

³² Ph.D., University of Trieste, 1938; Research Fellow, UC Berkeley, 1941-43; Visiting Research Professor, Yale University, 1956-58; Professor, Columbia University, 1958-64; Professor, Harvard University, 1964-67, Lucius N. Littauer Professor, 1967-74; Institute for Advanced Study, Member, 1972-73; Professor, 1974-85

оршдог. Аль нэг салбарын бүтээгдэхүүн өөр салбарын орц болдог, мөн тус салбар бусад салбарын бүтээгдэхүүнийг өөрийн үйлдвэрлэлдээ хэрэглэдэг. Тэгэхлээр салбар хоорондын эдгээр холбоосыг хоёр төрлийн байдаг гэж авч үзэж болно. Эрэлтийн холбоосууд (backward linkages) гэдэг нь тус салбар хөгжснөөр бусад салбарын бүтээгдэхүүнийг өөрийн үйлдвэрлэлийн орц болгон илүү ихээр шаарддаг тул тус орцын бүтээгдэхүүнийг нийлүүлдэг салбаруудад эрчимтэй өсөх боломж олдож байгаа юм. Жишээ нь, автомашины тээврийн салбар өссөнөөс болж шатахууны эрэлт өсөх болно, тиймээс шатахууныг нийлүүлдэг компаниудын борлуулалт нь нэмэгддэг. Үүнийг бол эрэлтийн холбоос гэж тодорхойлно. Уул уурхайн салбар өөрийн үйлдвэрлэлээ явуулахын тулд бусад салбараас техник, тоног төхөөрөмж, цахилгаан эрчим хүч, тээврийн үйлчилгээг ихээр худалдан авдаг. Уул уурхайн салбарын өсөлтийг дагаад эдгээр бүх салбарууд хөгжих болно, тиймээс уул уурхайн салбарын эрэлтийн холбоосууд голдуу эрчим хүч, дэд бүтэц, техникийн үйлдвэрлэлтэй илүү хүчтэй байдаг гэж болно.

Нийлүүлэлтийн холбоос (forward linkages) гэдэг нь тухайн салбарын бүтээгдэхүүнийн үйлдвэрлэл нэмэгдсэнээр бусад салбаруудын орц нэмэгдэж, тэдгээр салбарууд илүү хурдацтай өсч хөгжихийг хэлнэ. Жишээ нь, тариалангийн салбар хөгжвөл, үр тариаг боловсруулж гурил үйлдвэрлэдэг компаниуд илүү хөгжих бололцоотой болдог. Уул уурхайн салбарын хувьд ийм төрлийн холбоосууд голдуу хүнд аж үйлдвэртэй холбоотой байдаг юм, учир нь бүтээгдэхүүн голдуу хар ба өнгөр металл, эрдэс металл зэрэг зүйлүүд байдаг, түүнийг боловсруулаад эцсийн бүтээгдэхүүн гаргадаг салбаруудыг хүнд аж үйлдвэрт тооцдог.

Эрэлтийн холбоос нь хүчтэй байх тусмаа уул уурхайн салбарын өсөлтийг дагасан бусад салбаруудын өсөлт нь өндөр байх болно. Хэрэв уул уурхайн салбар хэрэглэх гол зүйлсээ гадаадаас импортоор авах юм бол эдгээр холбоосын хүч нь сулрах болно, өөрөөр хэлбэл дотоодын биш, гадаадын компаниудын үйлдвэрлэлийг дэмжиж, эх орондоо тус эрэлтээс бага юм үлдэх болно гэсэн. Уул уурхайн салбарт хэрэглэж байгаа гол тоног төхөөрөмж, машиныг Монголд голдуу гадаадаас худалдан авдаг, харин түүний үйлчилгээ, засварыг Монголд хийдэг тул машин, техникийн засварын үйлчилгээний эрэлт нь уул уурхайн салбарын өсөлтийг дагаад өсдөг.

Уул уурхайн салбарын нийлүүлэлтийн өсөлт нь металлын боловсруулалт, дэд бүтцийн хөгжил, бүс нутгийн хөгжлийн олон боломжийг шинээр үүсгэдэг бөгөөд түүнийг нийлүүлэлтийн холбоос гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, шинээр уурхайг нээж ажиллуулах нь тухайн бүс нутагт шинээр цахилгаан эрчим хүчний сүлжээг байгуулах, дэд бүтцийг хөгжүүлэхийг шаарддаг тул түүнийг дагаад бусад салбарууд, бүс нутаг нь өөрөө хөгжих болно. Өөрөөр хэлбэл, Монгол болон бусад орнуудад уул уурхайн салбар бүс нутгийн хөгжлийн тулгуур салбар юм, учир тус салбарын онцлогоос болж уурхайг байгалийн баялаг байгаа газарт нь л нээх боломжтой байдаг. Уурхайг ажиллуулахын тулд тус газар руу цахилгаан, ус, замын сүлжээг татаж байгуулдаг тул энэ нь эргээд бүс нутгийн хөгжлийн нөхцлийг нь бүрдүүлдэг. Монголын нөхцөлд уул уурхайн салбарын гол ач холбогдол нь үүнд оршиж байгаа юм. Орон нутагт төвөөс зайдуу оршиж байгаа газруудад хот суурин газрыг бий болгох нь асар их өндөр зардалтай байдаг боловч төм уурхайг дагаж

хотжилтыг хөгжүүлэх нь илүү амар, бага зардалтай байдаг. Иймээс уул уурхайн салбар Монголын хотжилт, бүс нутгийн хөгжлийн чухал тулгуур салбар болж байгаа юм. Монгол Улсад уул уурхайн салбар бүс нутгийн болон бусад салбаруудын хөгжилд ихээхэн нөлөө үзүүлснийг Эрдэнэт хотын жишээгээр авч үзэж болно. 1960-д онуудад хоосон тал байсан газарт одоо 100000 хүн амтай орчин үеийн хот сүндэрлэн боссон байгаа бөгөөд Эрдэнэтийн үйлдвэрийг цахилгаан, усаар хангах дэд бүтцийн хөгжлийг дагаад бусад салбарын жижиг том үйлдвэр, үйчилгээний газрууд олноор төрж бий болсон байна. Мөн тус үйлдвэрийн ажилчдын хэрэгцээг хангахын тул худалдаа, үйчилгээ, тээвэр, холбооны олон шинэ газрууд бий болсон. Энэ нь эргээд бусад төрлийн үйчилгээ, барааны эрэлтийг бий болгож байгаа юм

Дээрхи дурдсан эрэлтийн бөгөөд нийлүүлэлтийн холбоосыг эдийн засгийн онолд салбарын хоорондын нөлөөг тооцох аргачлаар тооцож, уул уурхайн салбар өөрөө бөгөөд бусад салбарын хөгжлийг бий болгох замаар нийтдээ хичнээн ажлын байрыг шинээр бүтээхийг тооцож болдог.

Уул уурхайн салбар бусад салбарын бараа, үйлчилгээний эрэлтийг үүсгэж, үйлдвэрлэлийг нь дэмждэг учир уул уурхайн салбар бусад салбарт ажил эрхлэлтийг бий болгодог ба түүнийг тооцож, *шууд бус ажил эрхлэлтийн үржүүлэгч* гэдэг үзүүлэлтээр хэмжиж болно (indirect employment multiplier)³³. Дээрхи хэсэгт бид АНУ, Австрали улсуудад уул уурхайн салбар бусад салбаруудад 2-3 ажлын байрыг, Энэтхэг, Чили, Филиппин зэрэг улсуудад 4-10 ажлын байрыг бий болгож байгааг харсан. Тэгвэл Монголд уул уурхайн салбар бусад салбаруудад хэдий хэмжээний ажлын байруудыг бий болгож байгаа вэ?³⁴

Судлаачдын тооцож үзсэнээр, Монгол улсад уул уурхайн салбар шууд бусаар бусад салбаруудад 3.8 ажлын байрыг бий болгодог. Эдгээр ажлын байрны 38%-ийг ХААд, 39%-ийг эрчим хүч болон үлдсэн 21%-ийг тээвэрт бий болгодог байна, өөрөөр хэлбэл уул уурхайн салбар 1 ажлын байр ХААд 1.4, эрчим хүчний салбарт 1.5 болон тээвэрт 0.8 ажлын байрыг бий болгодог.

Энэхүү шинээр бусад салбаруудад үүсч буй ажлын байрны харьцаа, уул уурхайн салбар өөрт бий болсон ажлын байрны харьцаа нь дээрхи дурдсан Чили, АНУ, Энэтхэгтэй харьцуулахад илүү Австрали, АНУ болон Чили улсуудын үзүүлэлтүүдтэй ижил байна (2.7, 2 ба 3.3), харин Энэтхэг болон Филиппинээс арай бага байна (6, 4-10). Энэ нь дараахи зүйлүүдтэй холбоотой гэж үзэж болно: нэгдүгээрт, Монгол дах уул уурхайн салбар зөвхөн Монголчуудын бус, гадаад ажилчдын ажлын бий болгож байна (албан есоор тус салбарт ажиллаж байгаа гадаадын хүмүүсийн тоо нийт салбарын ажиллагдсын 13%-ийг эзэлж байна), тиймээс тус салбар Монголд бий болгож байгаа цэвэр ажлын тоо арай доогуур гарч байна; хоёрдугаарт Монголд албан есны уул уурхайн салбарт хэрэглэж байгаа

³³ Аргачлалын хувьд уг тооцоог хийхдээ эхлээд салбар хоорондын балансыг ашиглаад уул уурхайн салбарын шууд бус үржүүлэгчийг тооцдог.

³⁴ Уг тооцоог уул уурхайн салбарын шууд бус үржүүлэгч, салбарын ажил эрхлэлтийн үржүүлэгчийг тооцсоны үндсэн дээр гавьяаг.

технологи, техник нь харьцангуй капитал эзлэмж ихтэй, машин тоног төхөөрөмж давамгайлсан техник байна; гуравдугаарт, нийт ажил эрхлэлтийг тооцохдоо дээрхи харьцааг түшиглэн албан бус ажил эрхлэлтийг нэмж оруулбал, уул уурхайн салбар Монгол Улсад өөрийн салбарт 40 мянган хүнийг, бусад салбаруудад 128 мянган хүнийг, мөн албан бус секторт улирлын шинж чанартай 100 мянган ажлын байрыг бий болгож нийтдээ 268 мянган хүнийг түр болон байнгын ажлын байраар хангаж байна гэсэн тооцоо гарч байна.